



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/МБ

Эмээлтөлгой

Түр хугацаанд хязгаарлалтын
дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг үндэслэн тарваган тахал өвчний сэжигтэй байж болзошгүй тохиолдол гарсантай холбогдуулан хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хугацаагаар хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Тарваган тахал өвчний сэжигтэй байж болзошгүй тохиолдол гарсантай холбоотойгоор эргүүл, постод ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Хязгаарлалтын дэглэмийг баримтлан, хяналтын постод гарч байгаа албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Түмэнжаргал), Сум дундын Цагдаагийн тасгийн дарга (Б.Алтангадас), Эрэн хайх, аврах салбарын дарга (Д.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Б.САРАНЦЭЦЭГ

642501175

Сумын Засаг даргын 2025 оны 09 дүгээр
сарын 26-ны өдрийн 2/118-р
захирамжийн хавсралт



ЭРГҮҮЛ, ПОСТОД АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Байгууллага	Өдөр
1.	ЗДТГ, ЭХАС, Цагдаагийн тасаг, ЭМТ	2025.09.26
2.	ЗДТГ, ЭХАС	2025.09.27
3.	ЗДТГ, ЭМТ	2025.09.28
4.	ЗДТГ, Цагдаагийн тасаг	2025.09.29

ооо